

Тайлангийн маягт, хавсралт мэдээ,
нөхөх заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2, 8.4, Татварын ерөнхий хуулийн 77 дугаар зүйлийн 77.7.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Оршин суугч бус хувь хүний орлогын албан татварын тайлан”-гийн маягт /ТТ-30/-ыг 1 дүгээр, “Оршин суугч бус хувь хүний орлогын албан татварын тайлангийн хавсралт мэдээ”-г 2 дугаар, “Оршин суугч бус хувь хүний орлогын албан татварын тайлангийн маягтыг нөхөх заавар”-ыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалын хавсралтаар батлагдсан тайлангийн маягт, хавсралт мэдээний загварыг Татварын удирдлагын нэгдсэн системд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, тушаалын хэрэгжилтэд хяналт тавихыг Татвар төлөгчид үйлчлэх газар /Д.Хүрэлчулуун/, Мэдээллийн технологийн төв /Х.Батбаяр/-д даалгасугай.

3. Батлагдсан маягтын дагуу тайланг хүлээн авч, татварын тооцоо хийхийг Том татвар төлөгчийн газар, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЗАЯАБАЛ

2.5.1. үнэ төлбөргүй, эсхүл хөнгөлөлттэй үнээр тээврийн хэрэгслээр үйлчилсэн	28	
2.5.2. орон сууцны ашиглалтын болон түрээсийн зардлын төлбөр, байрын хөлс, түлшний зардлын төлбөр	29	
2.5.3. үзвэр үйлчилгээний олговор	30	
2.5.4. ахуйн үйлчлэгч, жолооч, цэцэрлэгч болон бусад үйлчилгээ үзүүлсний зардлын төлбөр	31	
2.5.5. ажил олгогч, эсхүл бусад этгээдэд төлөх өр барагдуулсны төлбөр	32	
2.5.6. арилжааны зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээлийн хүүгийн зөрүү	33	
2.5.7. ажил олгогчийн төлсөн энэ хуулийн 11.2.7-д зааснаас бусад сайн дурын даатгалын хураамж	34	
2.5.8. гэр бүлийн гишүүний сургалтын төлбөр	35	
2.5.9. Монгол Улсад нүүж ирэх болон буцахтай холбогдон гарах зардлын төлбөр	36	
2.5.10. эрс тэс уур амьсгалд ажиллаж амьдарсны нэмэгдэл	37	
2.5.11. адилтгах бусад орлого	38	
2.6. Бусад орлого (40+41+42)	39	
2.6.1. урлаг, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал, тэдгээртэй адилтгах бусад орлого	40	
2.6.2. төлбөрт таавар, бооцоот тоглоом, эд мөнгөний хонжворт сугалааны орлого	41	
2.6.3. бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлого	42	
2.7. Монгол Улсад олсон орлогод ногдуулсан татвар (2*20%)	43	
3. Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлого (45+46+47+48+49+50+51+52+53)	44	
3.1. шууд болон цахим хэлбэрээр гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээ, Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бараанд Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч, төлөөний газраас олгосон орлого	45	
3.2. Гадаадын аж ахуйн нэгжийн Монгол Улсад зохион байгуулсан урлаг, соёл, спортын болон бусад арга хэмжээнээс олсон орлого	46	
3.3. Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчөөс олгосон ногдол ашгийн орлого	47	
3.4. Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, Монгол Улсад байрладаг албан татвар төлөгч, төлөөний газраас олгосон, шилжүүлсэн энэ хуулийн 9.4-т заасантай холбогдох хүүгийн орлого	48	
3.5. Монгол Улс дахь эзэмшил, ашиглалт, өмчлөлд байгаа хөрөнгө, тэдгээртэй холбоотой эрх борлуулсан, шилжүүлсэн, түрээслүүлснээс олсон орлого	49	
3.6. Монгол Улсад байрладаг албан татвар төлөгчөөс олгосон эрхийн шимтгэлийн орлого, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, биет бус хөрөнгө түрээслүүлсэн, ашиглуулсан болон ашиглах эрхийн орлого, санхүүгийн түрээсийн хүүгийн орлого, техникийн, удирдлагын, зөвлөхийн болон бусад үйлчилгээний орлого	50	
3.7. Албан татвар төлөгчийн төлөөний газрын эзэмшил, ашиглалт, өмчлөлд байгаа хөрөнгө, тэдгээртэй холбоотой эрх борлуулсан, шилжүүлснээс олсон орлого	51	
3.8. Төлөөний газрын үйл ажиллагаанд ашиглагдах хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө, биет бус хөрөнгө борлуулсан, түрээсэлснээс олсон орлого	52	
3.9. Адилтгах бусад орлого	53	
3.10. Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлогод ногдуулсан татвар (44*20%)	54	
4. Ногдуулсан татвар (43+54)	55	
5. Давхар татварын гэрээний дагуу хөнгөлөх татвар	56	
6. НИЙТ ТӨЛБӨЛ ЗОХИХ АЛБАН ТАТВАР (55-56)	57	

Тайланг үнэн зөв гаргасан:

Тайланг хүлээн авсан:

Захирал /дарга/

Татварын улсын байцаагч

Ерөнхий нягтлан бодогч

Итгэмжлэгдсэн нягтлан бодогч /...../

Татварын тайлан, хавсралт мэдээг
Татварын удирдлагын нэгдсэн системээс
үүсгээсэн кодоор баталгаажуулна.

Татварын ерөнхий газрын даргын
20... оны ... сарын ... -ны өдрийн
..... дугаар тушаалын хавсралт

Оршин суугч бус хувь хүний орлогын албан татварын тайлангийн хавсралт мэдээ

Татвар ногдох орлогын мэдээ /ХМ-30(1)/

(оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр)

Д/Д	Орлогын							Ногдуу лах албан татвар /ХХОАТ- ын хуульд заасан хувиар/	Давхар татварын гэрээний			Төлөх татвар	Оршин суугчийн гэрчилгээ ирүүлсэн эсэх	ДТ-01 маягтыг хавсар- гасан эсэх
	Огноо	Төрөл	Олгосон этгээдийн нэр	Улс	Дүн	Үүнээс:			Заалт	бууруулсан				
						Монгол Улсад олсон орлогын дүн	Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлогын дүн			Хувь	Дүн			
1	2	3	4	5	6=(7+8)	7	8	9	10	11	12=(7*11)	13=(8-12)	14	15
	Нийт дүн													

*Татварын тайлан, хавсралт мэдээг
Татварын удирдлагын нэгдсэн системээс
үүсгэсэн кодоор баталгаажуулна.*

Оршин суугч бус хувь хүний орлогын албан татварын тайлангийн маягыг нөхөх заавар

Энэхүү тайлангийн маягтаар Хувь хүний орлогын албан татварын тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 5 дугаар зүйлийн 5.5-д заасан Монгол Улсад оршин суугч бус албан татвар төлөгч нь энэ хуулийн 26 дугаар зүйлийн 26.5-т заасны дагуу дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор өссөн дүнгээр гаргаж, харьяа татварын албанд хүргүүлнэ.

Тайланг гаргахдаа Татварын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан “Татварын тайлан үйлдэх, тушаах, хүлээн авах, боловсруулах, тайланд залруулга хийх журам”-ыг баримтална. Тайланг нөхөхдөө 3 дугаар баганад тухайн үзүүлэлтийн дүнг оны эхнээс өссөн дүнгээр, төгрөгөөр бөглөнө.

Нэг.Албан татварын тооцоолол:

- 1.Нийт орлого буюу 1 дүгээр мөрийн дүн нь 2, 44 дүгээр мөрүүдийн нийлбэр дүнгээр тодорхойлогдоно.
- 2.Монгол Улсад олсон орлого буюу 2 дугаар мөрийн дүн нь 3, 11, 17, 22, 27, 39 дүгээр мөрүүдийн нийлбэрээр тодорхойлогдоно. Энэ дүн нь *Татвар ногдох орлогын мэдээ /ХМ-30(1)/-ний 7* дугаар баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.
- 3.Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого буюу 3 дугаар мөрийн дүн нь 4, 5, 6, 7, 8, 9, 10 дугаар мөрүүдийн нийлбэр дүнгээр тодорхойлогдоно.
- 4.Үйл ажиллагааны орлого буюу 11 дүгээр мөрийн дүн нь 12, 13, 14, 15, 16 дугаар мөрүүдийн нийлбэр дүнгээр тодорхойлогдоно.
- 5.Хөрөнгийн орлого буюу 17 дугаар мөрийн дүн нь 18, 19, 20, 21 дүгээр мөрүүдийн нийлбэр дүнгээр тодорхойлогдоно.
- 6.Хөрөнгө борлуулсан, шилжүүлсний орлого буюу 22 дугаар мөрийн дүн нь 23, 24, 25, 26 дугаар мөрүүдийн нийлбэр дүнгээр тодорхойлогдоно.
- 7.Шууд бус орлого буюу 27 дугаар мөрийн дүн нь 28, 29, 30, 31, 32, 33, 34, 35, 36, 37, 38 дугаар мөрүүдийн нийлбэр дүнгээр тодорхойлогдоно.
- 8.Бусад орлого буюу 39 дүгээр мөрийн дүн нь 40, 41, 42 дугаар мөрүүдийн нийлбэр дүнгээр тодорхойлогдоно.
- 9.Монгол Улсад олсон орлогод ногдуулсан татвар буюу 43 дугаар мөрийн дүн нь 2 дугаар мөрийн дүнг 20 хувиар үржүүлж гаргасантай тэнцүү байна.
10. Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлого буюу 44 дүгээр мөрийн дүн нь 45, 46, 47, 48, 49, 50, 51, 52, 53 дугаар мөрүүдийн нийлбэр дүнгээр тодорхойлогдоно. Энэ дүн нь *Татвар ногдох орлогын мэдээ /ХМ-30(1)/-ний 8* дугаар баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.
11. Монгол Улсаас эх үүсвэртэй олсон орлогод ногдуулсан татвар буюу 54 дүгээр мөрийн дүн нь 44 дүгээр мөрийн дүнг 20 хувиар үржүүлж гаргасантай тэнцүү байна.
12. Ногдуулсан татвар буюу 55 дугаар мөрийн дүн нь 43, 54 дүгээр мөрүүдийн нийлбэр дүнгээр тодорхойлогдоно. Энэ дүн нь *Татвар ногдох орлогын мэдээ /ХМ-30(1)/-ний 9* дүгээр баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.
13. Давхар татварын гэрээний дагуу хөнгөлөх татвар буюу 56 дугаар мөрийн дүн нь Монгол Улсаас бусад улстай байгуулсан Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээр бүхий улс орны татвар төлөгчийн уг хэлэлцээрийн дагуу хөнгөлөх татварын дүн байна. Энэ дүн нь *Татвар ногдох орлогын мэдээ /ХМ-30(1)/-ний 12* дугаар баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.
14. Нийт төлбөл зохих албан татвар буюу 57 дугаар мөрийн дүн нь 55 дугаар мөрийн дүнгээс 56 дугаар мөрийн дүнг хассан дүнгээр тодорхойлогдоно. *Татвар ногдох орлогын мэдээ /ХМ-30(1)/-ний 13* дугаар баганын нийлбэр дүнтэй тэнцүү байна.